ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ***ДУА-2019/133/СТА-ТШЗ***

Тэргүүлэх аудитор: П.ТӨВСАНАА
Утас: 7059-2439 Цахим хаяг: TuvsanaaP@audit.gov.mn
Аудитын менежер: Х.НАРАНЦАЦРАЛ
Утас: 7059-2225 Цахим хаяг: narantsatsaralkh@audit.gov.mn
Бэлтгэсэн аудитор: Б.ГАНТУЯА
Утас: 7059-3113 Цахим хаяг: gantuyab@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn
Мандалговь хот
2020 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

АГУУЛГА

1 Аудитын гэрчилгээ 3

2 Аудитын тайлан 5

2.1 Оршил 5

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага 5

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт 6

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин 6

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ 7

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал 7

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар 7

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн 8

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал ..... **Error! Bookmark not defined.**

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал 9

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга 9

2.11 Шилэн дансны мэдээлэл 9

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга 9

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл 10

3 Менежментийн захидал ..... **Error! Bookmark not defined.**

3.1 (Аудитын чиглэл) ..... **Error! Bookmark not defined.**

3.1.1 Илрүүлэлт: ..... **Error! Bookmark not defined.**

3.1.2 Эрсдэл: ..... **Error! Bookmark not defined.**

3.1.3 Өгсөн зөвлөмж: ..... **Error! Bookmark not defined.**

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: ..... **Error! Bookmark not defined.**

3.2 (Аудитын чиглэл) ..... **Error! Bookmark not defined.**

3.2.1 Илрүүлэлт: ..... **Error! Bookmark not defined.**

3.2.2 Эрсдэл: ..... **Error! Bookmark not defined.**

3.2.3 Өгсөн зөвлөмж: ..... **Error! Bookmark not defined.**

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: ..... **Error! Bookmark not defined.**

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан 10

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... **Error! Bookmark not defined.**

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 11

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 13

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 15

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... **Error! Bookmark not defined.**

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
[redacted]
Сангийн сан, Налайх баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgov@audit.gov.mn

2022 01 20 № 08
танай ____-ны №____

ДУНДГОВЬ АЙМГИЙН ОРОН
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ М.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-г заасны дагуу Орон нутгийн өмчийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үндэслэл, ажил гүйлгээнүүд материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын батлсан бодлого журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын батлсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг бүрэн илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, түүнд байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллын шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

[redacted]

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Орон нутгийн өмчийн газар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын батлагдсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР П.ТӨВСАНАА

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн шууд захирагч С.Уганбаярт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидлаар хүргүүлдэг.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалтад тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 16-наас 2020 оны 01 дүгээр сарын 25-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 01 дүгээр сарын 25-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Гантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 13-ний өдөр албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт, Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газар нь улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах, орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд хяналт тавин бүртгэл, тооллого явуулна гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл дунд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 2 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл түс бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь орон нутгийн төсвөөс санхүүждэгтэй холбоотой юм.

Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2019 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал нь 116,340.7 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 1,163.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь төлөвлөлтийн үе шатанд шинж чанар ба агуулгын хувьд материаллаг зүйл ажиглагдаагүйтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, бусад асуудлыг алдаа, зөрчилгүй гэж шийдвэрлэсэн, аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгээгүй.

Аудитын явцад хийсэн залруулга хийсэн эсэх талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
[illegible]				
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.0	
[illegible]				
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.0	
[illegible]				
	Дүн	1	1,050.0	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Төвлөрсөн халааллтай орон сууцанд амьдардаг 7 албан хаагчид нийт 1,050.0 мянган төгрөгийн түлш, халаалтын хөнгөлөлт олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь заалт */батлагдсан төсвийг зорилалтын дагуу зарцуулах/*, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 8.3 дахь хэсэг */Ердийн галлагаатай сууцанд амьдардаг төрийн албан хаагчид өвлийн улирлын түлш худалдан авах зардлын зохих хэсгийг байгууллагаас нөхөн олгож болно/*-ийг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг дахин давтан гаргуулахгүй байхаар хугацаатай албан шаардлага хүргүүллээ.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Аудитын явцад тулгарсан, дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц өөр чухал асуудал гараагүй.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд 115,337.8 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 115,333.7 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянасан.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

Энэ талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	**ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)**	**3,251,649.36**	**6,342,973.03**
33	**АВЛАГА**	**126,792.00**	**1,283,161.00**
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		1,003,457.00
33101	Цалингийн авлага		1,003,457.00
33500	Бусад авлага	126,792.00	279,704.00
33510	Байгууллагаас авах авлага	126,792.00	279,704.00
35	**БАРАА МАТЕРИАЛ**	**3,124,857.36**	**5,059,812.03**
35400	Хангамжийн материал	3,124,857.36	5,059,812.03
35410	Бичиг хэргийн материал	1,100,820.00	2,496,270.00
35420	Аж ахуйн материал	2,009,037.36	2,548,542.03
35450	Барилгын засварын материал	15,000.00	15,000.00
2	**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)**	**25,221,426.09**	**40,393,190.27**
39	**ҮНДСЭН ХӨРӨНГӨ**	**25,221,426.09**	**40,393,190.27**
39200	Биет хөрөнгө	23,613,426.09	38,845,190.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,843,610.01	5,843,610.01
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга		(584,361.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20,990,200.00	20,990,200.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(14,576,527.76)	(10,786,630.61)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	13,433,471.32	26,440,184.65
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(4,969,800.85)	(6,484,197.47)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,349,876.87	5,349,876.87
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(2,457,403.50)	(1,923,492.18)

39300	Биет бус хөрөнгө	1,608,000.00	1,548,000.00
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж		(60,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,308,000.00	1,308,000.00
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)**	**28,473,075.45**	**46,736,163.30**
4	**НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)**		
41	**БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР**		
41300	Өглөг		
41360	Бусад өглөг		
41361	Байгууллагад төлөх өглөг		
5	**ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)**	**28,473,075.45**	**46,736,163.30**
51	**Засгийн газрын хувь оролцоо**	**28,473,075.45**	**46,736,163.30**
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,308,000.00	1,308,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	24,348,399.59	42,611,487.44
51210	Өмнөх үеийн үр дүн	24,348,399.59	37,921,849.70
51220	Тайлант үеийн үр дүн		4,689,637.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,816,675.86	2,816,675.86
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)**	**28,473,075.45**	**46,736,163.30**

3.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)**	**101,502,887.36**	**121,030,300.00**
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	**9,314,887.36**	
1200	Нийтлэг татварын бус орлого	9,314,887.36	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,314,887.36	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,314,887.36	
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**92,188,000.00**	**121,030,300.00**
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,027,000.00	5,692,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,027,000.00	5,692,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	86,161,000.00	115,337,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	86,161,000.00	115,337,800.00
2	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)**	**105,010,019.11**	**116,340,662.26**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**105,010,019.11**	**116,340,662.26**
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	100,741,319.11	112,809,547.25
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	64,550,400.00	74,884,266.00
210101	Үндсэн цалин	57,574,700.00	51,895,871.06
210102	Нэмэгдэл	1,050,000.00	13,332,964.94

210103	Унаа хөөлны Хөнгөлөлт	2,557,800.00	5,246,350.00
210104	Урамшуулал	3,367,900.00	4,409,080.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,825,500.00	9,806,525.99
210201	Тэтгэврийн даатгал	5,251,600.00	6,716,445.68
210202	Тэтгэмжийн даатгал	613,200.00	799,170.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	533,400.00	610,976.00
210204	Ажилгүйдлийн даатгал	129,800.00	151,994.06
210205	Эрүүл мэндийн даатгал	1,297,500.00	1,527,940.15
2104	Хангамж, бараа материалын зардал	6,227,333.00	6,244,229.33
210401	Бичиг хэрэг	1,461,430.00	1,322,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,765,400.00	2,095,690.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,095,703.00	1,912,588.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		3,456.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	904,800.00	770,636.06
210408	Бараа материал актласны зардал		138,959.27
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	382,600.00	2,290,000.00
210604	Урсгал засвар	382,600.00	2,290,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,660,000.00	7,282,000.00
210702	Дотоод албан томилолт	2,660,000.00	7,282,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,784,600.00	3,424,297.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,165,100.00	2,380,261.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	515,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125,500.00	125,436.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	132,000.00	132,000.00
210807	Газрын төлбөр		8,770.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,310,886.11	8,878,228.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,536,300.00	
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	552,000.00	115,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	12,222,586.11	8,763,228.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,268,700.00	3,531,115.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,268,700.00	3,527,050.00
213206	Эзлэхийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	77,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,191,700.00	3,527,050.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		4,065.01
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		4,065.01
3	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)**	**(3,507,131.75)**	**4,689,637.74**

5	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)**	**604,979.92**	
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	604,979.92	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	604,979.92	
6	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)**	**(4,112,111.67)**	**4,689,637.74**

3.2 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)**	**92,188,000.00**	**121,030,300.00**
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**92,188,000.00**	**121,030,300.00**
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,027,000.00	5,692,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,027,000.00	5,692,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	86,161,000.00	115,337,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгуулага/	86,161,000.00	115,337,800.00
2	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗӨЭЛИЙН ДҮН (II)**	**92,188,000.00**	**107,650,300.00**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**92,188,000.00**	**107,650,300.00**
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	87,919,300.00	104,119,184.99
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	64,550,400.00	72,869,266.00
210101	Үндсэн цалин	57,574,700.00	49,880,871.06
210102	Нэмэгдэл	1,050,000.00	13,332,964.94
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	2,557,800.00	5,246,350.00
210104	Урамшуулал	3,367,900.00	4,409,080.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,825,500.00	9,806,525.99
210201	Тэтгэврийн даатгал	5,251,600.00	6,716,445.68
210202	Тэтгэмжийн даатгал	613,200.00	799,170.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	533,400.00	610,976.00
210204	Ажилгүйдлийн даатгал	129,800.00	151,994.06
210205	Эрүүл мэндийн даатгал	1,297,500.00	1,527,940.15
2104	Хангамж, бараа материалын зардал	5,589,900.00	8,337,596.00
210401	Бичиг хэрэг	833,200.00	2,698,350.00
210402	Тээвэр, шатахуун	1,765,400.00	2,095,690.00
210403	Цуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,017,300.00	2,071,000.00
210404	Ном, хэвлэл		20,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		3,456.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	974,000.00	1,449,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	397,600.00	2,290,000.00
210604	Урсгал засвар	397,600.00	2,290,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,660,000.00	7,282,000.00

210702	Дотоод албан томилолт	2,660,000.00	7,282,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,807,600.00	3,418,797.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,188,100.00	2,374,761.00
210802	Аудит, баталгаажуулалт, зөрэглэл тогтоох	240,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	515,830.00
210804	Тээврийн хэрэгслийн тигвар	125,500.00	125,436.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	132,000.00	132,000.00
210807	Газрын төлбөр		8,770.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,088,300.00	115,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,536,300.00	
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	552,000.00	115,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,268,700.00	3,531,115.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,268,700.00	3,527,050.00
213206	Эзэлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	77,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,191,700.00	3,527,050.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		4,065.01
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		4,065.01
3	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)**		**13,380,000.00**
4	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)**		
5	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)**		**13,380,000.00**
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**		**13,380,000.00**
223	БУСАД ХӨРӨНГӨ		13,380,000.00
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		13,380,000.00
6	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)**		**(13,380,000.00)**
9	**САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН**		
10	**САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**		
7	**САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)**		
8	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)**		
14	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**		
15	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**		

3.3 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	**2017 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл**			**28,460,511.37**	**28,460,511.37**
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(11.00)	(11.00)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			28,460,500.37	28,460,500.37
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		2,816,675.86		2,816,675.86
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,308,000.00			1,308,000.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн				
8	**2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл**	**1,308,000.00**	**2,816,675.86**	**24,348,399.59**	**28,473,075.45**
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			13,573,450.11	13,573,450.11
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,308,000.00	2,816,675.86	37,921,849.70	42,046,525.56
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз				
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
15	**Тайлант үеийн үр дүн**			**4,689,637.74**	**4,689,637.74**
16	**2019 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл**	**1,308,000.00**	**2,816,675.86**	**42,611,487.44**	**46,736,163.30**

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР Б.ГАНТУЯА

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.НАРАНЦАЦРАЛ

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР П.ТӨВСАНАА